



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Аудитын нэр: Цэцэрлэг сумын төрийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүн гүйцэтгэлийн аудит

ХӨА-2018/04-ГА

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/125 дугаар тушаал, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 онд хийх аудитын төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн гүйцэтгэлийн аудитын тайлан



ЗДТГ-ын байр –Цэцэрлэг сум

**ЦЭЦЭРЛЭГ СУМЫН
ИТХ, ЗАСАГ ДАРГА
НЬ ЧИГ ҮҮРГЭЭ
ХАНГАЛТГҮЙ
ХЭРЭГЖҮҮЛСЭН
БАЙНА.**



Могойн хүүхдийн цэцэрлэгийн байр

Хөвсгөл аймаг Мөрөн хот
2018 он



Могойн хүүхдийн гэр цэцэрлэг

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:

Хөвсгөл аймаг дахь
Төрийн аудитын газар

Санхүүгийн тайлангийн
аудитын баг

Тэргүүлэх аудитор
О. Ганболд
Аудитын менежер
Г. Эрдэнэчимэг
Ахлах аудитор
Б.Тэгшдэлгэр
Аудитор
Л.Магсаржалам
Аудитор
С.Гансүх

2018 оны 6 сар

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж
тодруулах, асууж лавлах
зүйл байвал 70384043
дугаарын утас, 70383793
дугаарын факсаар
харилцана уу

ХАЯГ: Мөрөн сум
Аймгийн ЗДТГ-ын “А”
корпус 3 давхар
Цахим хаяг: audit.gov.mn

Товчилсон үгийн тайлбар

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Бүлэг 1. Сумын Засаг даргын үр дүнгийн гэрээний биелэлтийг 60,8% буюу хангалтгүй гэж үнэлсэн байна.

1.1. Сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргын өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн байна.

1.2. Төрийн захиргааны албан хаагчдын үр дүнгийн гэрээг журмын дагуу үнэлж, дүгнээгүй байна.

Бүлэг 2. Төсвийн тухай хуулийн холбогдох заалтууд болон УИХ, ЗГ-аас гаргасан төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх арга хэмжээг баримтлан ажиллаагүй байна.

2.1. ЗДТГ, ИТХ нь төсвийн тодотгол нэрээр төсвийг хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

2.2. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага зөвлөмжийн биелэлт хангалтгүй байна.

Дүгнэлт

Зөвлөмж

Зөрчлийн жагсаалт

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

МУ	Монгол Улс
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ИТХТ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ХӨА	Хөвсгөл аймаг
ГА	Гүйцэтгэлийн аудит
УИХ	Улсын их хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗГ	Засгийн газар
МУЗЗНДНТУХ	Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ОНО	Орон нутгийн орлого
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ЗД	Засаг дарга
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
БИНХ	Багийн иргэд нийтийн хурал
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ХХК	Хариуцлагатай хувьцаат компани
ЭЭС	Эмийн эргэлтийн сан
ЭМ	Эрүүл мэнд
ЭМНДГ	Эрүүл мэнд нийгмийн даатгалын газар
ЭМТ	Эрүүл мэндийн төв

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, бүрэлдэхүүн

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2018 оны А/125 дугаар тушаалаар батлагдсан Хөвсгөл аймаг дахь төрийн аудитын газрын 2018 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Хөвсгөл аймаг дахь Төрийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт

Цэцэрлэг сумын төрийн байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүнг шалган дүгнэлт, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, үр дүнг олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ.

Дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэв.

Үүнд:

- Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүн хангалттай эсэх
- Төсвийн хөрөнгийн зарцуулалт үр ашигтай эсэх

Аудитын хамарсан хүрээ

Аудитад Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын төсөвт байгууллагуудын 2017 оны удирдлагын болон санхүүгийн үйл ажиллагаа тэдгээртэй холбогдох баримт материалыг хамруулав.

Аудитын явцад төсөвт байгууллагууд болон төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллагуудаас ирүүлсэн судалгаа, удирдлагын шийдвэр, ажлын баримт, холбогдох албан тушаалтантай ярилцлага явуулсны дүнд ерөнхий эрсдэлийг “ИХ” гэж үзлээ.

Аудитын арга зүй

Аудитын явцад Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмжийг мөрдөж, шалгагдагч байгууллагын албан тушаалтнуудтай ярилцлага хийх, холбогдох баримтыг гаргуулан авч нэгтгэн дүн шинжилгээ хийх, харьцуулах зэрэг гүйцэтгэлийн аудитын гарын авлагад дурдсан арга зүйг ашиглаж, аудитын горимын дагуу нотлох баримт цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох баримт, холбогдох мэдээ, судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитад хамрагдсан хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа дараах хууль, эрхийн акт, баримт бичгийг аудитын шалгуур болгон ашигласан. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Бага дунд боловсролын тухай хууль
- Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль
- Эрүүл мэндийн тухай хууль
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актууд

Гүйцэтгэлийн аудитыг хийхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх журам, гүйцэтгэлийн шалгалтын журам, аймгийн Тэргүүлэх аудиторовын баталсан гүйцэтгэлийн аудитын төлөвлөгөө хөтөлбөрийг удирдлага болгон ажиллалаа.

Аудит хийсэн бүрэлдэхүүн

Гүйцэтгэлийн аудитыг Тэргүүлэх аудитор О.Ганболд удирдаж, аудитын менежер Г.Эрдэнэчимэг чанарын хяналтыг хэрэгжүүлэн, Аудитын газрын ахлах аудитор Б.Тэгшдэлгэр, аудитор Л.Магсаржалам, С.Гансүх нар 2018 оны 05 дугаар сарын 01-нөөс 06 дугаар сарын 31-ны дотор аудитыг хийж гүйцэтгэсэн.

Цэцэрлэг суманд 2018 оны 5 дугаар сарын 20-30-ний хооронд ажилласан ба 2018 оны 05 дугаар сарын 30-ны өдөр албан байгууллагуудын удирдлага, нягтлан бодогч, нярав, ажилчдын дунд өргөтгөсөн хурал хийж, аудитын урьдчилсан дүнг танилцуулсан болно.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн шалгалтын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох баримт, холбогдох мэдээ, судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Сумын Засаг даргын 2017 оны үр дүнгийн гэрээний биелэлтийг 60,8% буюу хангалтгүй гэж үнэлсэн байна.

Бүлэг 1

1.1 Сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргын өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн байна.

Үндсэн мэдээлэл:

Цэцэрлэг сум нь 1931 онд үүсгэн байгуулагдсан. Засаг захиргааны нэгжийн хувьд Дэлгэрхаан, Зуунмод, Ренчинжугнай, Уранхайрхан, Халбан, Жаргалант, Бүрхээр гэсэн 7 багтай, 7480 м² газар нутагтай, 1280 өрхтэй, 4539 хүн амтай, 261075 толгой малтай, газар нутгийн байршлын хувьд аймгийн төвөөс алслагдсан, нэлээдгүй томоохон сумын тоонд орж байна.

Тухайн суманд төрийн үйлчилгээг иргэдэд хүргэдэг нийт 8 төрийн байгууллага үйл ажиллагаа явуулж байна. **Үүнд:** Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын тамгын газар, Ерөнхий боловсролын сургууль, Эрүүл мэндийн төв, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Могойн эрүүл мэндийн төв, Могойн хүүхдийн цэцэрлэг, Могойн бага сургууль зэрэг байна.

Төрийн үйлчилгээний чиглэлээр: 2017 онд сумын Засаг даргаас үндсэн үйл ажиллагааны чиглэлээр 142, боловсон хүчний чиглэлээр 12 захирамж, нийт 154 захирамж гаргасан байна. Сумын ард иргэдэд дараах төрлийн үйлчилгээг төрийн нэрийн өмнөөс хүргэж ажиллаж байна. Үүнд:

- ✓ Иргэний, эд хөрөнгийн, хуулийн этгээдийн бүртгэлийг бүртгэх
- ✓ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ
- ✓ Халамжийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх үйлчилгээ
- ✓ Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх
- ✓ Эрүүл мэнд нийгмийн даатгалын үйлчилгээ
- ✓ Бүрэн дунд болон сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ
- ✓ Эрүүл мэндийн үйлчилгээ

Томоохон салбаруудын үйл ажиллагааны талаар дурдвал дараах байдалтай байна.

Үүнд:

Эрүүл мэндийн чиглэлээр: 2017 онд Эрүүл мэндийн төв нь удирдлага зохион байгуулалт, санхүү аж ахуйн үйл ажиллагааг тогтмолжуулах, нийгмийн баталгааг хангах, тогтвор суурьшилтай ажиллуулах, иргэдэд нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай хүргэж тэдний мэдлэг хандлагыг сайжруулах, тусламж үйлчилгээ зонхилон тохиолдох өвчнийг оношлох, эмчлэх үйл ажиллагааны чанар хүртээмжийг сайжруулах гэх мэт хүн амын эрэлт хэрэгцээнд тулгуурлан түүний практик үр өгөөжийг дээшлүүлэх 7 зорилтын хүрээнд 55 үйл ажиллагаа явуулсан байна. 2017 онд сумын Эрүүл мэндийн төвд 374 хүн хэвтэн эмчлүүлсэн байна.

Боловсролын чиглэлээр: Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг нь 2017 онд багш боловсон хүчнийг хөгжүүлэх, сургалтын ажлыг сайжруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулсан. Зөв монгол хүүхэд хөтөлбөрийн хүрээнд монгол зан үйлийг эцэг эхтэй нь хамтран зохион байгуулсан. Эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх үүднээс эцэг эхчүүдийн дунд уралдаан тэмцээн явуулж ЭМТөвтэй хамтран 12 төрлийн сургалт зөвлөгөөн зохион байгуулж ажилласан байна. Цэцэрлэгийн гал тогоог стандартын дагуу болгож засварлах үйл ажиллагаа явуулсан. Хүүхдийн анги танхимын хүрэлцээг нэмэгдүүлэн сурах таатай орчныг бүрэлдүүлэн ажилласан.

1.1.1. Сумын хөгжлийн бодлогын баримт бичгийг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн дагуу боловсруулаагүй байна.

2016 оны орон нутгийн сонгуулийн үр дүнгээр томилогдсон Засаг дарга Г.Цогт нь бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөр болон 2016-2020 онд Цэцэрлэг сумыг хөгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг сумын ИТХТ-ын хуралдааны 2017.06.30-ны 01 тоот тогтоолоор батлуулсан байна.

Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулахдаа Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дахь заалтын дагуу зорилго, зорилтын хүрэх түвшин, хугацаа, санхүүгийн эх үүсвэр тус бүрийг тодорхой тусгаж боловсруулаагүй байна.

Сумын Засаг дарга аймгийн Засаг даргатай 2017 онд хамтран ажиллах үр дүнгийн гэрээг 2016.12.26-нд нэг жилийн хугацаатай байгуулсан ба 1-8 хавсралтаар нийт 107 бүтээгдэхүүн нийлүүлэхээр гэрээ хийсэн байна.

Аймгийн Засаг дарга тус сумын Засаг даргын үр дүнгийн гэрээний биелэлтийг 60,8% буюу гэрээгээр хүлээсэн үүргээ “хангалтгүй” хэрэгжүүлсэн гэж дүгнэсэн байна.

Цэцэрлэг сумын ЗДТГ-ын 2017 оны үйл ажиллагааг аймгийн Засаг даргын 2018 оны 02 дугаар сарын 02-ний А/74 дүгээр захирамжийн дагуу үнэлэхэд дараах байдалтай байна. **Үүнд:**

№	Чиглэл	Үнэлгээ
1	Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	53,7
2	Байгууллагын чиг үүргийн үзүүлэлт	82,2
3	Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	41,1
4	Дундаж үнэлгээ	56,9

Аймгийн Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт, ЗДТГ-ын үйл ажиллагааны үнэлгээ хангалтгүй байгаа тул аймгийн Засаг даргын 2018 оны А/97 дугаар захирамжаар тус сумын Засаг дарга Д.Цогт, ЗДТГ-ын дарга Н.Пүрэвсүрэн нарт сахилгын шийтгэл ногдуулсан боловч одоо болтол дээрх арга хэмжээг авч

хэрэгжүүлээгүй байна.

Дээрх алдаа зөрчлүүд нь гүйцэтгэлийн аудитын явцад баримтаар нотлогдож байна.

Тухайлбал:

- ✓ Хөгжлийн бодлогын баримт бичгүүдийг хууль журмын дагуу боловсруулаагүй, гүйцэтгэлийг хянах боломжгүй.
- ✓ Аймгийн Засаг даргатай байгуулсан сумын Засаг даргын гэрээг баримталж ажиллаагүй, сумын Засаг дарга, ЗДТГ-ын дарга нарт гэрээний нэг хувь байхгүй, гүйцэтгэлийг гаргаж аймагт ирүүлсэн боловч тэр нь өөр сумаас /Ханх сумын ЗДТГ-аас авсан/ үзүүлэлтийг авч гүйцэтгэл гаргаж хүргүүлсэн.

Сумын удирдлагын зүгээс төрийн бодлого, төрөөс ард иргэдэд үзүүлж буй үйл ажиллагааг хүргэн үйлчилж байгаа төсөвт байгууллагуудыг удирдлага, арга зүйгээр хангах, хийсэн ажлыг нь үнэлэн дүгнэх ажиллагаа орхигдсон байдлаас шалтгаалан төрийн албан хаагчдын харьцаа хандлага төлөвшөөгүй, төсөвт байгууллагуудын үйл ажиллагаа урсгалаар явагддаг, аливаа төрийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангадаггүй зэрэг зөрчил дутагдал газар авч төрийн бодлого шийдвэрт итгэх ард иргэдийн итгэл алдарсан байна.

Төрийн байгууллагуудын ажлын байрны хангалт, төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл байдлыг судлахад нэлээд хүндрэлтэй байна. **Тухайлбал:**

- ✓ ЗДТГ-ын албан контор, Соёлын төвийн барилга, сургуулийн 2 хичээлийн байрыг ашиглах боломжгүй тул аймгийн МХГ-ын улсын байцаагчийн дүгнэлт гарсан ч өдий хүртэл үйл ажиллагаа явуулж байна.

- ✓ Могойн хүүхдийн цэцэрлэг өөрийн гэсэн байргүй, одоогийн байдлаар 2 гэрт үйл ажиллагаа явуулж байна.



Төрийн албан хаагчдын ажиллах таатай нөхцөл, аюулгүй байдлыг хангах тал дээр анхаарал хандуулах шаардлагатай байна. Төрийн үйлчилгээ явуулж байгаа албан контор ийм байгаа нь төрийн үйлчилгээний чанар хүртээмж муудах, төрийн ажилчдын ажлын цаг ашиглалт сулрах гэх мэт сөрөг талуудыг дагуулж байна.

1.1.2. Багийн Засаг дарга нартай үр дүнгийн гэрээ байгуулж, биелэлтийг тооцохгүй байна.

Аймгийн Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний 3.4 дэх заалтад Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төсвийн шууд захирагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам”-ын дагуу орон нутаг дахь төсвийн байгууллагын шууд захирагч нартай үр дүнгийн гэрээ байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт үр дүнг бодитой тооцон ажиллах талаар тусгасан байна. Үүний дагуу сумын Засаг дарга сумын ЗДТГ-ын дарга, Эрүүл мэндийн төвийн дарга, Соёлын төвийн эрхлэгч нартай үр дүнгийн гэрээ байгуулсан байна.

Дараах төсвийн шууд захирагч нартай 2017 онд үр дүнгийн гэрээ байгуулж ажиллаагүй байна. Үүнд:

- ✓ Сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал
- ✓ Могойн хүүхдийн цэцэрлэг, бага сургуулийн захирал
- ✓ Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч
- ✓ Багийн Засаг дарга

Үр дүнгийн гэрээ байгуулж ажилласан төсвийн шууд захирагч нарын гэрээний биелэлтийг дараах байдалтай үнэлсэн байна. Үүнд:

№	Төсвийн захирагч	шүүд	Овог нэр	Үнэлгээ
1	ЗДТГ-ын дарга		Б.Пүрэвсүрэн	85%
2	Эрүүл мэндийн төвийн дарга		Баатар	99,5%
3	Соёлын төвийн эрхлэгч		Аззаяа	90%

Төсвийн шууд захирагч нарын үр дүнгийн гэрээг үнэлэхдээ Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Менежерийн үйл

ажиллагааны үр дүн, мэргэжлийн түвшинг үнэлж дүгнэх журам”-ын дагуу бодитой үнэлээгүй нь аудитаар нотлогдож байна. **Тухайлбал:** Аймгийн Засаг даргын 2018 оны А/74 дүгээр захирамжийн 1 дүгээр хавсралтаар сумдын ЗДТГ-ын 2017 оны үйл ажиллагааг үнэлэхэд тус сумын ЗДТГ нь 56,9%-ийн үнэлгээ авсан, сумын ЭМТ нь 2017 онд батлагдсан төсвийг тээвэр шатахуун эмийн зардлыг арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулсан байна.

Сумын Эрүүл мэндийн төвийн дарга, нөгөө талаас тухайн сумын Засаг дарга болон Эрүүл мэндийн төвийн дарга нар харилцан тохиролцож “хариуцлага хамтын ажиллагааг сайжруулах гурвалсан гэрээг байгуулаагүй байна.

1.1.3. Дотоод хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэхгүй байна.

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 1.5 дахь заалтын дагуу байгууллагын дарга, захирал, эрхлэгч нар “Дотоод хяналтын нэгж”-ийг томилсон байна. Үүнд:

- ✓ ЗДТГ-ын 2016.12.07-ний А/18 дугаар тушаалаар
- ✓ ЗДТГ-ын 2018 оны А/06 дугаар тушаалаар шинэчилсэн
- ✓ Ерөнхий боловсролын сургуулийн захирлын 2018 оны 1 сарын 2-ны тушаалаар
- ✓ Эрүүл мэндийн төвийн даргын 2016.02.22-ний А/06 дугаар тушаалаар
- ✓ Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгчийн 2016,02,03-ны А/09 дугаар тушаалаар
- ✓ Могойн Эрүүл мэндийн төвийн даргын 2017 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 07 тоот тушаалаар тус тус “Дотоод хяналтын нэгж”-ийг томилон ажиллуулсан байна.

“Дотоод хяналтын нэгж”-үүд нь дээрх “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-д нийцүүлэн байгууллага тус бүр дээрээ дотоод хяналтыг зохион байгуулах журмыг боловсруулж батлуулаагүй ба зөвхөн байгууллагын дарга нараар батлуулсан удирдамжийн дагуу дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна.

2017 онд дотоод хяналтыг хэрэгжүүлсэн тоог байгууллага тус бүрээр нь гаргавал дараах байдалтай байна. **Үүнд:**

№	Байгууллагын нэр	тоо	Чиглэл
1	ЗДТГ	5	Ажлын цаг ашиглалт, ажлын байрны тодорхойлолт, эд хөрөнгийн бүртгэл, мэдээ тайлангийн хугацаа чанар, тусгай сангуудын зээлийн эргэн төлөлт, төсөв санхүүгийн ил тод байдал зэрэгт дотоод хяналт хийсэн байна.
2	Ерөнхий боловсролын сургууль	2	Үдийн цай, дотуур байрны хүүхдийн тоо, ажлын цаг ашиглалтын байдалд дотоод хяналт хийсэн байна.
3	Эрүүл мэндийн төв	24	Ажилчдын ажлыг дүгнэх,эмнэлгийн тусламж үйлчилгээ мөрдөж байгаа стандартын хэрэгжилт,дүрэм журамд зааварчилгаа өгөх, хянах гэх мэт эрүүл мэндийн үйлчилгээ болон өмчийн бүртгэл тооцоо, ашиглалт, хадгалалт хамгаалалт, санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийсэн байна.
4	Хүүхдийн цэцэрлэг	7	Хүүхдийн ирцийн бүртгэл, анги дүүргэлт нас насандаа байгаа эсэх,эрүүл мэндийн шинжилгээнд бүрэн хамрагдсан, эмчийн зөвшөөрөлтэй хүүхэд авсан эсэх, анги бүлэг гал тогооны цэвэрлэгээ үйлчилгээнд, хүүхдийн хоол хүнсний хадгалалт хамгаалалт, хичээлийн хэрэглэл ариун цэврийн хэрэглэгдэхүүний хэрэглээ зарцуулалт зэрэгт хяналт хийсэн байна.
6	Могойн бага сургууль	1	Дотуур байрны хүүхдийн тоо, цаг ашиглалтын байдалд хяналт хийсэн.
7	Могойн хүн эмнэлэг	17	Цэвэрлэгээ үйлчилгээ, эмнэлгийн угаалга, ажлын цаг ашиглалт,гадна дотны цэвэрлэгээ,АШБ хөтлөлт,эм хоолны цэсэнд хяналт хийсэн байна.

Дотоод хяналтын нэгж нь хяналт шалгалтыг тодорхой хэмжээнд зохион байгуулж байгаа ч тэдгээрийн ажлын тайлан, илрүүлсэн зөрчлийг арилгаж чадсан эсэхийг аудитаар хянаж үзэхэд алдаа зөрчил дахин давтагдсан, хяналтыг ор нэр төдий хэрэгжүүлсэн, өөрийн байгууллагын онцлогт тохирсон дотоод хяналтын журам боловсруулаагүй зэрэг зөрчил дутагдал байна. **Тухайлбал:**

- ✓ ЗДТГ-т дотоод хяналтын нэгж нь ажлын цаг ашиглалтыг нягтруулах, хоцрогдлыг арилгах талаар удаа дараа анхааруулж ажилласан боловч ажлын цаг баримтлахгүй байдал ажиглагдаж байна. Аудитын явцад сумын иргэдийн зүгээс “ЗДТГ-ын болон төрийн байгууллагын ажиллагсад ажилдаа цагтаа ирдээгүй” гэсэн гомдол шүүмжлэл нэлээдгүй гарч байсан болно.
- ✓ 2017 онд ЭМТөв, Могойн хүн эмнэлгийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт үнэлгээ хийгээгүй байна.

1.2 Төрийн захиргааны албан хаагчдын үр дүнгийн гэрээг журмын дагуу үнэлж, дүгнээгүй байна.

1.2.1. Батлагдсан орон тооны хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна.

Төсөвт байгууллагууд нь 2017 онд батлагдсан орон тоонд хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна. **Үүнд:**

№	Байгууллагын нэр	ЗДТГ		ИТХ		ЕБС		Хүүхдийн цэцэрлэг		Соёлын төв		Могойн цогцолбор		ЭМТ		Могойн хүн эмнэлэг	
		төлөв	гүйц	төлөв	гүйц	төлөв	гүйц	төлөв	гүйц	төлөв	гүйц	төлөв	гүйц	төлөв	гүйц	төлөв	гүйц
1	Удирдах	10	10	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
2	Гүйцэтгэх ажилтан	13	13	1	1	47	47	13	13	3	3	6	6	22	22	4	4
3	Үйлчлэх ажилтан	2	2			28	28	3	3	1	1	7	7	7	7	3	3
4	Гэрээт	3	1													3	3
5	Нийт	28	26	2	2	76	76	17	17	5	5	14	14	30	30	11	11

Дээрх хүснэгтээс харахад: 2017 онд батлагдсан орон тоо хэтрүүлсэн байгууллага байхгүй байна.

1.2.2. Төрийн захиргааны албан хаагчдын үр дүнгийн гэрээг журмын дагуу үнэлж, дүгнээгүй байна.

Цэцэрлэг сумын төсвийн байгууллагуудын дарга, захирал, эрхлэгч нар 2017 онд ажилтан албан хаагчидтай батлагдсан “Журам”-ын дагуу үр дүнгийн гэрээ, төрийн үйлчилгээний албан хаагчидтай Хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу хөдөлмөрийн гэрээг тус тус байгуулан ажилласан байна.

Ажлын байрны тодорхойлолтыг байгууллага тус бүр дараах байдалтай боловсруулж батлуулсан байна. Үүнд:

- ✓ **ЗДТГ-ын хувьд**-ЗДТГ-ын дотоод ажил хариуцсан ажилтан боловсруулж ЗДТГ-ын даргаар батлуулж байна.
- ✓ **Эрүүл мэндийн төв, Могойн хүн эмнэлгийн хувьд**- Эрүүл мэндийн сайдын 2012 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 182 тоот тушаалын тавдугаар хавсралтын дагуу сумын Эрүүл мэндийн төвийн дарга ажлын байрны тодорхойлолт боловсруулж баталж байна.
- ✓ **ЕБС, Хүүхдийн цэцэрлэгийн хувьд**- Боловсрол соёл шинжлэх ухааны сайдын 2007 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 351 тоот тушаалын хавсралтын дагуу сумын ЕБС-ийн захирал, Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч нар ажлын байрны тодорхойлолт боловсруулж баталж байна.

Аудитаар нийт 43 төрийн албан хаагчийн хувийн хэргийн бүрдүүлэлт, үр дүнгийн гэрээ, хөдөлмөрийн гэрээ байгуулсан эсэх, ажлын байрны тодорхойлолтод заасан шаардлага хангасан албан тушаалтныг ажиллуулсан эсэх, түүний үр дүнг үнэлсэн эсэхийг хянаж үзэхэд дараах зөрчил илэрч байна. Үүнд:

- ✓ ЗДТГ-ын ажилчдын хувийн хэргийн бүрдүүлэлт хангалтгүй, баяжилт хийгээгүй, заавал байх баримт бичгүүд байхгүй, үр дүнгийн гэрээний илтгэх хуудсыг Төрийн

албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан “Журам”-ын дагуу үнэлж, дүгнээгүй байна.

- ✓ Сумын санхүүгийн албаны даргын ажлыг түр орлон гүйцэтгэж байгаа Ч.Энхтуяа нь тус ажлын байрны **“төрийн албанд 3-аас дээш жил ажилласан, ажлын дадлага туршлагатай байх”** гэсэн ажлын байрны тодорхойлолтод заасан шаардлагыг хангаагүй.
- ✓ Сумын ЗДТГ-ын зарим мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтыг боловсруулж байгаа боловч холбогдох албан тушаалтны гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулаагүй байна.

Төсвийн тухай хуулийн холбогдох заалтууд болон УИХ, ЗГ-аас гаргасан төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх арга хэмжээг баримтлан ажиллаагүй байна.

Бүлэг 2

2.1. ЗДТГ, ИТХ нь төсвийн тодотгол хийж төсвийг арилван хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулах боломжийг бий болгосон байна.

Үндсэн мэдээлэл

Цэцэрлэг сумын төсвийн төвлөрүүлэн захирагч 2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлсэн ба орон нутгийн төсвөөс 504554,3 мянган төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс 2030105,7 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 6455,6 мянган төгрөг, Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт 49470,0 мянган төгрөг дансны эхний үлдэгдэл 39314,5 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих 17060,4 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн орлого 45268,0 мянган төгрөг нийт 2640096,5 мянган төгрөгөөр санхүүжүүлэн гүйцэтгэлийг хангуулсан ба гүйцэтгэл 94,6 хувьтай байна.

Сумын ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн ээлжит 9 дүгээр хуралдааны 34 дүгээр тогтоолоор сумын төсөвт байгууллагуудын 2017 оны төсвийг баталсан байна. Тухайн жилийн төсөвт 3 удаа тодотгол хийсэн. Сумын ОНХС-ийн өмнөх оны дансны үлдэгдэл 2627,0 мянган төгрөгийг сумын ИТХ-ийн 2017.06.30-ны 06 тоот тогтоолоор тодотгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 34.2 дахь заалтыг зөрчсөн байна. Төсөвт байгууллагууд анх батлагдсан төсвийг дараах байдалтай тодотгосон байна. **Үүнд:**

/мян.төг/

№	Байгууллагын нэр	Анх батлагдсан	Тодотгол		Тодотгосон дүн
			Нэмэх	Хасах	
1	ЗДТГ	336113,9	116316,5	634,2	451796,2
2	ИТХ	42158,4	19259,8		61418,2
3	Эрүүл мэндийн төв	349399,2	11500,0		360899,2
4	Ерөнхий боловсролын сургууль	1025057,9	26013,5		1051071,4
5	Хүүхдийн цэцэрлэг	218427,1	5736,0		224163,1
6	Соёлын төв	72176,8		1167,0	71009,8
7	Могойн эмнэлэг	88224,6			88224,6

Сумын ОНО-ыг 2017 онд 53,1 сая төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 147,2 сая төгрөг болж, 94,1 сая төгрөгийн орлогыг давуулан биелүүлсэн ба үүний 74,8%

нь ан агнуурын хураамжаас /шонхор/ орсон орлого байна. Шонхор шувуу бариулсны орлогыг сүүлийн 3 жилийн байдлаар харуулбал дараах байдалтай байна. **Үүнд:**
/мян.төг/

Үзүүлэлт	2015 он	2016 он	2017 он
Гүйцэтгэл	38400,0	38400,0	70550,0

Хүснэгтээс харахад: Сүүлийн 3 жилийн байдлаар тус сумын орлого энэ хэмжээгээр давж биелсэн үзүүлэлттэй

байна.

Ойн нөөц ашигласны төлбөр 12,7 сая төгрөгөөр, бууны татвар 0,9 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

2.1.1. Сумын ИТХ, ЗДТГ нь төсөвт тодотгол хийж батлагдсан төсвийг үр ашиггүй, хэмнэлтгүй зарцуулж байна.

Цэцэрлэг сумын төсөвт байгууллагуудын 2017 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитаар төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бусаар зарцуулсан, Төсвийн тухай хуулийн холбогдох заалтууд болон УИХ, ЗГ-аас гаргасан төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх арга хэмжээг баримтлан ажиллаагүй дараах зөрчлүүд илэрч байна. Үүнд:

ЗДТГ-ийн хувьд:

- ✓ УИХ-ын 2017 оны 67 дугаар тогтоолын дагуу төрийн албан хаагчдад олгох нэг удаагийн тэтгэмж урамшуулал олгохдоо ЗГХЭГ-ын 2017 оны 52 дугаар хуралдааны тэмдэглэлд заасныг зөрчин 2017 онд сахилгын шийтгэлтэй байсан нягтлан бодогч М.Отгон-өлзий, байгаль орчны хяналтын улсын байцаагч Б.Очиртойм, жижиг дунд үйлдвэр, бэлчээр газар тариалан хариуцсан мэргэжилтэн Д.Отгонтуяа нарт урамшуулал олгосон байна. Урамшуулалд олгосон 729,0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.
- ✓ ЗДТГ-ын спорт заалыг иргэн Л.Пүрэвжаргалтай 7 сарын хугацаатай, сарын 200,0 мянган төгрөгөөр түрээсийн гэрээ байгуулсан ба 2017 онд түрээсийн орлого 1074,0 мянган төгрөгийг орон нутгийн орлогод оруулсан ба 326,0 мянган төгрөгийг өдий хүртэл төлөөгүй байна. Иймд иргэн Л.Пүрэвжаргалаар 326,0 мянган төгрөг төлүүлэх төлбөрийн акт тогтоов.
- ✓ ЗДТГ-ын бараа материалын тайланг хянаж үзэхэд хүнсний зүйл худалдан авах болон хоолны зардалд 2017 онд 3751,6 мянган төгрөгийг зарцуулж, үр ашиггүй зардал гаргасан байна.
- ✓ Тээвэр шатахууны зардалд 2017 онд нийт 22980,0 сая төгрөг зарцуулснаас 15358,1 мянган төгрөгийн шатахууны зардлын тооцоо бодоогүй, томилолтын зардлыг тээвэр шатахууны зардлаар хааж төсвийг өөр зүйл заалтаар зарцуулсан байна.
- ✓ ЗДТГ-ын урсгал засварын зардлаас 12755,0 мянган төгрөгөөр урсгал засвар хийсэн нь УИХ-ын 2016 оны 47 дугаар тогтоолын в-ийн 4 /эмнэлэг, цэцэрлэг, сургуульд зайлшгүй урсгал засвар хийхээс бусад тохиолдолд төсвийн байгууллагын албан контор, ажлын байранд урсгал засвар хийхгүй байх/ гэснийг зөрчсөн байна. Мөн дээрх урсгал засварыг өдий хүртэл хийж эхлээгүй зөвхөн материал бэлтгэсэн байна.
- ✓ 2016 оны давсан орлогоос ЗДТГ-ын албан хэрэгцээнд 29000,0 мянган төгрөгөөр автомашин худалдан авсан нь УИХ-ын 2016 оны 47 дугаар тогтоолын в-ийн 6 /төсвийн хөрөнгөөр автомашин худалдан авахгүй байх/ заалтыг зөрчсөн байна.

- ✓ ЗДТГ-т 4,0 сая төгрөгийн грашийг хуурамч бичиг баримтаар орлогод авсан нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7¹-г тус тус зөрчсөн байна.
- ✓ 2017 онд ЗДТГ нь зардлын зүйл анги тус бүр дээр 2 удаагийн тодотголоор 116316,5 сая төгрөгийн нэмэлт тодотгол хийсэн байна. ЗДТГ-ын төсвийн шууд захирагч, төсвийн тодотгол нэрээр батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулж, төсвийн үр ашгийг бууруулж, үрэлгэн байдлыг бий болгосон байна. **Тухайлбал:** 2017 онд ЗДТГ-ын цалингийн зардалд 8928,1 мянган төгрөгийн тодотгол хийлгэж, түүнийг ЗДТГ-ын дарга Н.Пүрэвсүрэнгийн ур чадварын нэмэгдлийг 20%-иар нэмэгдүүлсэнтэй холбоотой 1759,2 мянган төгрөг, ЗДТГ-ын нягтлан бодогч М.Отгон-өлзийгийн цалингийн шатлал нэмэгдүүлсэнтэй холбоотой 685,3 мянган төгрөг, өвсний фондын сахиулын цалинд 1776,0 мянган төгрөг, ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч нарт 2016 оны балансын урамшуулал 1342,3 мянган төгрөг, Г.Оюунчимэгийн цалингийн нэмэгдлийг дутуу тооцсон 1095,2 мянган төгрөг, нягтлан бодогч Г.Энхжаргал, М.Отгон-өлзий нарын цалингийн тооцоололтой холбоотой 241,4 мянган төгрөг нийт 6901,5 мянган төгрөгийн зардал гаргасан байна.
- ✓ Сумын санхүүгийн үйл ажиллагаанд төрийн сангийн зүгээс тавих хяналт хангалтгүй, санхүүгийн албанаас нягтлан бодогчдыг удирдлага арга зүйгээр хангаж ажиллахгүй байна.

ИТХ-ын хувьд:

- ✓ Сумын ИТХ-ын даргын 2017.12.21-ны 10 тоот захирамжаар 7 хүнд 1260,0 мянган төгрөгийн урамшуулал олгохдоо өөртөө / Ч.Дашдаваа-д/ 180,0 мянган төгрөгийн урамшуулал олгох шийдвэр гаргасан нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1² дахь заалтыг зөрчсөн байна.
- ✓ ЭМНДГ-ын хяналтын байцаагчийн тавьсан 441,0 мянган төгрөгийн төлбөрийн актыг сумын ИТХ-ын төсвөөс шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5³ дахь заалтыг зөрчсөн байна. Дээрх 621,0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоов.

2017 онд сумын ЗДТГ, ИТХ-ын төсвийг 3 удаа тодотгож баталсан байна. *Төсөвт тодотгол хийсэн байдлыг хянаж үзэхэд:* ЗДТГ, ИТХ-ын байгууллагууд нь 2017 онд батлагдсан урсгал төсвийг нэр төрөл тус бүр дээр нь тодотгож, төсвийг хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулах нөхцөлийг бий болгосон байна. Тус суманд давсан орлого, дансны үлдэгдлийг зөвхөн ИТХ, ЗДТГ-ын урсгал зардлыг нэмж санхүүжүүлдэг жишиг тогтсон байна. **Тухайлбал:**

2017 онд сумын ЗДТГ-ын төсвийг 82,1 сая төгрөгөөр, ИТХ-ын төсвийг 12,8 сая төгрөгөөр тус тус тодотгосон байна. Мөн 2018.04.06-ны өдрийн сумын ИТХ-ын хуралдааны 01 тогтоолоор 2017 оны дансны үлдэгдэл 18,2 сая төгрөгөөр ИТХ-ын төсвийг 5,7 сая төгрөгөөр, ЗДТГ-ын төсвийг 9,8 сая төгрөгөөр тус тус нэмж тодотгосон байна. Дээрх давсан орлогын 6,9 сая төгрөгийг биеийн тамир уралдаан тэмцээний зардалд, 2,0 сая төгрөгийг тээвэр шатахууны зардалд, 0,7 сая

¹ 13.7. Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.

² 11.1. Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

³ 16.5.5. батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;

төгрөгийг дотоод албан томилолтын зардалд, 1,0 сая төгрөгийг бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардалд, 3,0 сая төгрөгийг урсгал засварын зардалд тус тус зарцуулахаар төлөвлөсөн байна.

Ерөнхий боловсролын сургуулийн хувьд:

- ✓ Ерөнхий боловсролын сургуулийн захиралд 277,4 мянган төгрөгийн, Могойн бага сургууль, хүүхдийн цэцэрлэгийн захиралд 203,7 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгохдоо тушаал шийдвэргүйгээр олгосон. Нийт 481,1 мянган төгрөгөд төлбөрийн акт тогтоов.

Эрүүл мэндийн төвийн хувьд:

- ✓ Эрүүл мэндийн төв нь 2017 онд НДШимтгэлд 239,2 мянган төгрөг, тээвэр шатахууны зардалд 1217,3 мянган төгрөг, эмийн зардалд 5249,9 мянган төгрөг, маягтад 307,0 мянган төгрөг бүгд 7013,4 мянган төгрөгийн өр үүсгэж ажилласан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8⁴ дахь заалтыг зөрчсөн тул дахин давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлж байна.
- ✓ Эрүүл мэндийн төв нь 2017 онд тендерээс авах ёстой эм 8711,9 мянган төгрөг буюу 62,2%-ийг татан авч 5204,0 мянган төгрөг буюу 37,8% татан авалт хийгээгүй байна. *Нэг өвчтөнд ногдох эмийн зардал төлөвлөснөөр 29640 төгрөг, гүйцэтгэлээр 50067 төгрөг байна. Жишээлбэл: Эмийн эргэлтийн сангийн болон тендертэй эмийн үнийг харуулбал дараах байдалтай байна.*

№	Эм, материалын нэр	Тендертэй эмийн үнэ	ЭЭС-ийн үнэ	Зөрүү
1	Бээлий	8700	15000	6300
2	Анальгин	275	1000	725
3	Цефазолин	560	1500	940
4	Кокор	1230	3000	1770
5	Ренгер	3177	7000	3823

Хүснэгтээс харахад: Эмийн өр үүссэн гол шалтгаан нь тендерийн эмийн худалдан авалтыг бага хийж, өндөр үнэтэй ЭЭСангаас эм авч хэрэглэсэн нь эмийн өр үүсэх гол шалтгаан болж байна.

- ✓ Сумын ЭМТөв 2017 онд 2372 л буюу 3795,2 мянган төгрөгийн шатахууныг анхан шатны баримтгүйгээр зарцуулсан, тээвэр шатахууны батлагдсан төсвийг 1223,4 мянган төгрөгөөр хэтрүүлсэн. 2018 онд эхний 5 сарын байдлаар 13450,4 мянган төгрөгийн шатахуун авч хэрэглэсэн. "Түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлсэн бүртгэл", жолоочийн тооцооны хуудас, шаардах хуудас анхан шатны ажил гүйлгээний баримттай тулган баталгаажуулалтыг /2018 оны 1-5 сар/ хийхэд дуудлагын журналд бичигдээгүй дан шаардах бичиж зөвхөн ЭМТөвийн даргын бичгээр авсан А80 1841л, А92 333л Дизел Түлш 300л нийт 4489,9 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан зөрчил илэрсэн.

Хүснэгтээр харуулбал

Хаашаа явсан	А80	А92	Дизел түлш	Нийт дүн
Мөрөн	817	313	65	2164,7
Дуудлаганд	1024	20	235	2325,2
Дүн	1841	333	300	4489,9

2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил дахин давтагдсан тул баримтын бүрдэлгүй шатахуун зарцуулахгүй, дахин давтан гаргахгүй байх, анхан шатны баримтыг бүрдүүлж тооцоо бодож дуусгах хугацаатай албан шаардлага хүргүүлж байна.

⁴ 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.

- ✓ ЭМТөвийн даргад 2017 оны 3 дугаар сард 131,1 мянган төгрөг, 12 дугаар сард 81,9 мянган төгрөг нийт 212,9 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгохдоо тушаал шийдвэргүйгээр олгосон зөрчилд 212,9 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

Хүүхдийн цэцэрлэгийн хувьд:

- ✓ Хүүхдийн хоолны зардлаас хүүхдүүдэд Эх үрсийн баяр болон шинэ жилээр бэлэг өгч хүүхдийн хоолны зардлыг 1761,3 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

Могойн эрүүл мэндийн төвийн хувьд:

- ✓ Могойн Эрүүл мэндийн төвийн дарга 2017 оны 3 сард 81,0 мянган төгрөг, 11 дүгээр сард 292,5 мянган төгрөг нийт 372,5 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгохдоо тушаал шийдвэргүйгээр олгосон зөрчилд 372,5 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

Аудитын хугацаанд сумын Эрүүл мэндийн төв нь 641,0 мянган төгрөгийн томилолтын зардал, 1557,2 мянган төгрөг урсгал засварын зардал /сэлбэг/ нийт 2198,2 мянган төгрөг, сумын Хүүхдийн цэцэрлэгт 739,8 мянган төгрөгийн томилолтын зардалд тус тус анхан шатны баримтыг бүрдүүлэн ажилласан.

Эмийн эргэлтийн сангуудын талаар:

“Өгөөмөр баялаг”, “Ариун жугнай” ХХК-иудыг 2018 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн Хөвсгөл аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн хуралдааны 2-р тогтоолоор татан буулгаж “Хөвсгөлийн эмийн эргэлтийн сан” ОНӨХК-ийн салбар болгохоор шийдвэрлэсэн байна. “Ариунжугнай”, “Өгөөмөр баялаг” ХХК-иуд нь 2017 онд нягтлан бодох бүртгэл бүрэн хөтлөөгүй, нярвын тайлан гаргуулж тооцоо бодоогүй, их хэмжээний авлага өглөг үүсгэн, бүртгэлээр тавих хяналт хангалтгүйгээс эмийн худалдан авалт болон хувь хүнд борлуулсан орлогыг дутуу тайлагнах нөхцөлийг бий болгосон байна.

2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд баталгаажуулахад “Өгөөмөр баялаг” ХХК нь **“Санал дүгнэлт өгөхөөс татгалзах”** санал дүгнэлт авсан, “Ариунжугнай” ХХК нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасан цаглабарын хугацаанд аудитын байгууллагад санхүүгийн тайлангаа ирүүлээгүй байна.

Эмийн эргэлтийн сангууд нь санхүүгийн болон гүйцэтгэлийн аудитад шаардлагатай баримтууд дутуу, татан буугдаж шинэ компанид нэгдэн орж байгаа, хуучин ажилтнуудын ихэнх нь байхгүй, төлөөлөн удирдах зөвлөл татан буугдсан, шинээр байгуулагдсан компани дээр холбогдох баримтууд шилжиж ирээгүй зэрэг хүндрэлтэй асуудлуудаас шалтгаалан бүрэн хэмжээнд явуулах боломж бүрдээгүй болно.

2.1.2. ОНХС-ийн хөрөнгийг Төсвийн тухай хууль 60.3.6 дах заалт болон Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан зааврын дагуу зарцуулахгүй байна.

ОНХС-ийн талаар: Сумын ОНХС-д 2017 онд нийт 17060,4 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсан байна. Аудитаар ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжигдэх төсөл арга хэмжээний санал асуулгыг хуулийн хугацаанд явуулсан гэх ямар ч нотлох баримт байхгүй байна. Үүнд:

1. Ард иргэдээс авсан санал асуулгын хуудас байхгүй
2. БИНХ-ын хурлын тогтоол, ирцийн талаарх мэдээлэл байхгүй

3. Сумдын ЗДТГ-т эрэмбэлсэн ажлын хэсгийн тайлан, ажлын хэсэг томилсон тушаал шийдвэр байхгүй байна. Энэ нь Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах” журмын 12.2.1, 12.2.2, 12.2.3, 12.2.4, 12.2.5 дахь заалтуудыг тус тус зөрчиж байна.

2017 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 3 ажлыг сумын ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 20 өдрийн 01 тоот тогтоолоор баталсан байна. Үүнд:

№	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Гүйцэтгэл	Ард иргэдээс санал авсан эсэх	ЗДТГ-т эрэмбэлэгдсэн эсэх	ИТХ-аар батлагдсан эсэх	Зураг, төсөв, ТЭЗҮ, техникийн тодорхойлолт байсан эсэх
1	Баяр наадмын зардал	5000,0	5000,0	Хуулийн дагуу		Тийм	
2	Нийтийн үйлчилгээний граж	4000,0	4000,0	Тодорхойгүй	Тодорхойгүй	Тийм	Байхгүй
3	Гудамж талбай камержуулах	8060,4	8000,0	Тодорхойгүй	Тодорхойгүй	Тийм	Тийм
4	Нийт	17060,4	17000,0				

Энэ байдлаас харахад ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6⁵ дахь заалтыг зөрчиж байна. Сумын ОНХС-ийн өмнөх оны дансны үлдэгдэл 2627,0 мянган төгрөгийг 2017.06.30-ны 06 тоот тогтоолоор дараах зүйлд зарцуулахаар нэмж тодотгосон байна. **Үүнд:**

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн ерөнхий боловсролын сургуулийн 320 хүүхдийн хичээлийн байрны зураг, төсвийн үнэд 1654,4 мянган төгрөг,
- Өвс тэжээлийн фонд барих ажлын дутуу санхүүжилт 972,6 мянган төгрөгийн өрийг төлөх шийдвэр гаргасан байна.

ОНХС-ийн гүйцэтгэлтэй холбоотой дараах зөрчил илэрч байна. Үүнд:

- Нийтийн үйлчилгээний граж барих ажлыг гэрээний хугацаанд хийж гүйцэтгээгүй байхад “Жарантайн намаг” ХХК-д 2017.12.24-нд 4000,0 мянган төгрөгийг шилжүүлсэн ба анхан шатны баримт материалыг хуурамчаар хийж гүйцэтгэн баталгаажуулсан байна. /”**Жарантайн намаг**” ХХК-ны тоот, ажил хүлээн авсан ажлын хэсгийн акт зэрэг нь хуурамч байна./ Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6, 13.7 дахь заалтыг зөрчиж байгаа тул 4000,0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоож байна.
- Гудамж талбай камержуулах ажлын гэрээг 8000,0 мянган төгрөгөөр “Жигүүр Фүүд” ХХК-тай гэрээ хийсэн, гүйцэтгэгчээс гэрээнд заасан дүнгээр нэхэмжлэл ирүүлсээр байтал 8060,4 мянган төгрөг шилжүүлж 60,4 мянган төгрөгийг илүү олгосон байна. Иймд дээрх 60,4 мянган төгрөгийг буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоож байна.

⁵ 60.3.6.орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ.

3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн ерөнхий боловсролын сургуулийн 320 хүүхдийн хичээлийн байрны зураг төсвийн үнэд 2013 онд 17900,0 мянган төгрөг, 2015 онд 6234,7 мянган төгрөг, 2017 онд 1654,4 мянган төгрөг нийт 25789,1 мянган төгрөгийг ТЭТҮ ХХК-д шилжүүлсэн ба зураг төсвийг орлогод аваагүй, авлагаар бүртгээгүй байна. Иймд дээрхи хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгах албан шаардлагыг хүргүүлж байна.
4. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны баримт материалыг архивын нэгж болгож үдэж цэгцлээгүй, хууль журмын дагуу явуулсан баримт материал байхгүй байна. Аймгийн Орон нутгийн өмчийн газраас ирүүлсэн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй байна. Иймд сумын 7 багийн Засаг дарга, БИНХ-ын дарга, сумын ЗДТГ-ын дарга нарт хариуцлага тооцон ажиллах санал хүргүүлж байна.

Малжуулах төсөлд хамрагдсан өрхүүдийн зээлийн эргэн төлөлтийн талаар: Малжуулах төслийн өрийн үлдэгдэл 2017 оны жилийн эхэнд 65,2 сая төгрөг байсан ба 2017 онд 11,6 сая төгрөг, 2018 оны эхний 5 сарын байдлаар 20,6 сая төгрөгийн эргэн төлөлт хийгдэж, 33,1 сая төгрөгийн үлдэгдэл байна.

Сум хөгжүүлэх сангийн талаар: Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн олголт, зээлийн ашиглалт эргэн төлөлтийн тоон мэдээллийг 2017 оны 4 сарын 30-ны байдлаар гаргалаа.

Сум хөгжүүлэх санд одоогийн байдлаар нийт 61 хүнтэй холбоотой 181,2 сая төгрөгийн үндсэн зээл хүүгийн авлагатай байна. Харилцах дансанд 32,0 сая төгрөгийн үлдэгдэл байна.

2018 оны 4 сарын 30-ны өдрийн байдлаар сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн мэдээллийг хүснэгтээр харуулбал: /сая төгрөгөөр/

Анх олгосон зээл, эргэн төлөх хүүгийн төлбөрийн хуваариар			Нийт төлсөн дүн	Үлдэгдэл			Хугацаа хэтэрсэн зээл		
Зээлийн хэмжээ	хүү	Нийт төлөх дүн		хүүгийн үлдэгдэл	үндсэн зээл	нийт дүн	хүүгийн үлдэгдэл	үндсэн зээл	нийт дүн
247.6	186.6	267.6	72.4	135.6	175.4	181.2	10.2	118.4	128.7

51 зээлдэгчтэй холбоотой хугацаа хэтэрсэн зээлийн хүү 10.2 сая төгрөг, үндсэн зээл 118.4 сая төгрөг бүгд 128.7 сая төгрөг байна. Хугацаа хэтэрсэн зээлтэй холбоотой 6.1 сая төгрөгийн хүүгийн орлого олох боломжийг алдсан байна.

Аудитын явцад нийт 25 зээлдэгчтэй биечлэн болон утсаар холбогдож санал асуулга явуулж, судалгаа авсан болно.

Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл байгуулагдан ажиллаж байна. Зөвлөл нь сонгон шалгаруулалт хийхдээ зээлийн эргэн төлөлтийн судалгаагүй, төслийн дагуу үйл ажиллагаа явуулах нь тодорхойгүй төслийг сонгон шалгаруулсан алдаа зөрчил гаргасан байна. **Тухайлбал:**

- ✓ Зээлийг олгохдоо нэг дор бөөн дүнгээр төлүүлэхээр эргэн төлөх хуваарь хийж, зээлдэгчийн үйл ажиллагаа болон эргэн төлөлтөд эхнээс нь хяналт тавьдаггүй зөрчил дутагдлын улмаас хугацаа хэтэрсэн зээл, хүүгийн хэмжээ нийт сангийн хөрөнгийн 60 хувьд хүрээд байна.

- ✓ 2017 онд олгосон зээлээс иргэн Л.Батхүүгийн Жаазны үйлдвэр байгуулах төсөл, иргэн И. Өлзийсайханы Зайрмагны цех байгуулах төслийн нийт 14.5 сая төгрөгийн зээлийг зориулалтын дагуу зарцуулаагүй, ямар нэгэн үйл ажиллагаа явуулж эхлээгүй байна.

Нийт 32 хүний 83.9 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээл, хүүгийн авлага шүүхээр шийдвэрлүүлэх шатанд явж байна.

2.1.3. Худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу ил тод зохион байгуулж, хэвшээгүй байна.

Сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2.2.1 дахь заалтын дагуу тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг төсвийн төслийн хамт боловсруулж, хэлэлцүүлж, батлуулаагүй байна.

Суманд явагдах худалдан авах ажиллагааг ажил үүргийн хуваарийн дагуу сумын орлогч дарга гардан зохион байгуулж байгаа ч архивын нэгж болгон үдэж цэгцэлсэн бичиг баримт байхгүй байна.

Сумын ЗДТГ, ИТХ нь урсгал төсвөөр худалдан авах бараа, ажил үйлчилгээний төлөвлөгөөг гаргаж, түүний дагуу худалдан авалт хийж байгаа ч, худалдан авах ажиллагааг зохион байгуулах, ил тод байдлыг хангах, тайлагнах зэрэг ажлуудыг “журам”-ын дагуу явуулсан гэж нотлох баримт материал хангалтгүй байна. **Тухайлбал:** Шууд худалдан авах гэрээ байгуулсан ч 3 аас дээш аж ахуйн нэгж байгууллагад үнийн санал хүргүүлэх, ил тод нээлттэй зарласан эсэх нь тодорхойгүй байна.

Сумын ЗДТГ-т 29000,0 мянган төгрөгөөр худалдан авах автомашины худалдан авах ажиллагааг аймгийн Орон нутгийн өмчийн газарт зохион байгуулсан байна.

Сумын Эрүүл мэндийн төв нь Эм ханган нийлүүлэх байгууллагатай эмийн худалдан авалтын гэрээ хийхдээ гэрээний тусгай нөхцөлд эмийн нэр төрөл, нэгжийн үнийг тодорхой зааж тусгаагүй тогтмол бус үнээр эмийн худалдан авалт хийсэн, гэрээний биелэлт дүгнээгүй ба энэ нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 40.3 49.2.10, Төсвийн тухай хуулийн 16.5.2 дугаар заалтуудыг зөрчсөн үйлдэл болсон байна

ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны баримт материалыг архивын нэгж болгоогүй, худалдан авах ажиллагаа зохион байгуулсан баримт материал хангалтгүй байна.

Эдгээр нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 48 дугаар зүйл, Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-д заасан худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах, ил тод байдлыг хангах заалтуудыг тус тус зөрчсөн зөрчил илэрч байна.

2017 онд төсөвт байгууллагуудад үнэ төлбөргүй болон хандиваар ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусган ажилласан эсэхийг аудитаар тулган шалгахад ЗДТГ-ын тайланд тусгагдсан 4000,0 мянган төгрөгийн нийтийн граш биетээр оршин байхгүй байна. Бусад зүйлсийн хувьд зөрүүтэй зүйл гараагүй болно.

2.2. Өмнөх хяналт шалгалтаар өгөгдсөн акт, албан шаардлага зөвлөмжийн биелэлт хангалтгүй байна.

2.2.1. Сумын төсвийн төвлөрүүлэн захирагч 46 мэдээлийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хугацаа хоцроож байршуулсан байна.

Төрийн байгууллагуудад Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд дараах байдалтай байна. Хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. **Үүнд:**

Байгууллагын нэр	Төсөв /гүйцэтгэлтэй холбоотой мэдээлэл /ширхэгээр/			Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалттай холбоотой мэдээлэл /ширхэгээр/			Бусад мэдээлэл /ширхэгээр/		
	Хугацаандаа байрлуулсан	Хугацаа хоцорсон	Байрлуулаагүй	Хугацаандаа байрлуулсан	Хугацаа хоцорсон	Байрлуулаагүй	Хугацаандаа байрлуулсан	Хугацаа хоцорсон	Байрлуулаагүй
Төсвийн төвлөрүүлэн захирагч	48	24	3	16	10	1	25	12	
ЗДТГазар	48	1		39			61		
ИТХурал	47	2		39			61		
Цэцэрлэг сумын ЭМТ	49			39			59	2	
Могойн ЭМТөв	47	2		36	3		58	3	
Цэцэрлэгийн ЕБСургууль	49			39			61		
Могойн бага сургууль	49			39			61		
Цэцэрлэг сумын Хүүхдийн цэцэрлэг	49			39			61		
Могойн хүүхдийн цэцэрлэг	49			39			60	1	
Соёлын төв	49			39			61		
Нийт	484	29	3	364	13	1	568	18	

Дээрх хүснэгтээс харахад:
Цэцэрлэг сумын ЕБСургууль, Могойн бага сургууль, Соёлын төв, Цэцэрлэг сумын Хүүхдийн цэцэрлэг байрлуулбал зохих мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн байрлуулж, ЗДТГазар,

ИТХурал, Цэцэрлэг сумын Эрүүл мэндийн төв, Могойн Эрүүл мэндийн төв, Могойн Хүүхдийн цэцэрлэг шилэн дансанд байршуулбал зохих 149 мэдээллээс 1-8 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд 139 мэдээлэл шилэн дансанд байршуулахаас 89 мэдээллийг цаг хугацаанд нь байршуулсан боловч 46 мэдээллийг хугацаа хоцроож, 4 мэдээллийг байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл 1”Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална ”Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”;6 дугаар зүйлийн 1”Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

2.2.2. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

Цэцэрлэг сумын төрийн байгууллагуудад 2016 оны санхүүгийн тайлангаар 30 зөвлөмж өгснөөс 26 зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна. 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд өгсөн зөвлөмжүүдийн хэрэгжилтийг дутуу ханган биелүүлснээс зөрчил дахин давтан гарсаар байна.

Тус суманд сүүлийн жилүүдэд жил бүр санхүүгийн тайлангийн аудит, ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт нийцлийн аудит, Хөрөнгө оруулалтын үр өгөөж гүйцэтгэлийн аудит болон аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт шалгалтуудыг хийж, акт, албан шаардлага, тодорхой зөвлөмжүүдийг хүргүүлж байгаа боловч биелэлт хангалтгүй байна. **Тухайлбал:**

- ✓ ЭМТөв дээр шатахууны зардлыг анхан шатны баримтгүйгээр зарцуулсан
- ✓ Сум хөгжүүлэх сангийн авлага буураагүй хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн авлага өссөн

- ✓ ЗГ-ын 2014 оны 147 дүгээр тогтоол, УИХ-ын 2016 оны 47 дугаар тогтоолыг төсөв, санхүүгийн үйл ажиллагаандаа хэрэгжүүлж тэвчиж болох зардлыг аль болох хязгаарлах гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй
- ✓ ОНХС-д хийсэн нийцлийн аудитаар өгсөн акт, албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй, холбогдох хууль, журам, зааврын тодорхой заалтуудыг зөрчин үйл ажиллагаа явуулсан
- ✓ Аймгийн санхүүгийн хяналт, аудитын албаны улсын байцаагч нарын тавьсан актыг биелүүлж ажиллаагүй

Хөвсгөл аймаг дах Төрийн аудитын газраас 2017 онд хийсэн “ОНХС-ийн зарцуулалт” нийцлийн аудитаар тус сумын ИТХ-ын дарга Ч.Дашдаваад хүргүүлсэн *ҮАГ/НАГ/2017/01-НА-ХөААГ-14/16* тоот албан шаардлагыг биелүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын байгууллагын акт, албан шаардлагыг хэрэгжүүлэн ажиллахгүй байгаа албан тушаалтанд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2 дахь заалтын дагуу арга хэмжээ авч ажиллах нь зүйтэй гэж аудитаар үзэж байна.

Аудитаар нийт **469,9** сая төгрөгийн зөрчил илрүүлж, **52,6** сая төгрөгийн албан шаардлага, **6,9** сая төгрөгийн акт тогтоож, **410,1** сая төгрөгийн зөрчилд дахин давтахгүй байх зөвлөмж, хариуцлага тооцон ажиллах санал 2-ыг хүргүүлж байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Цэцэрлэг сумын Засаг дарга бүрэн эрхийнхээ хугацаанд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөр болон сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн дагуу боловсруулан батлуулаагүйгээс төрийн үйлчилгээг иргэнд хүргэх ажил хангалтгүй, аймгийн Засаг даргын өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн байна.
2. Сумын зарим төсөвт байгууллагуудын үйл ажиллагаа явуулах байшин барилга нь ашиглах боломжгүй болж, МХГ-ын улсын байцаагчийн дүгнэлт гарсан тул төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, таатай орчин бүрдэхгүй байна.
3. Сумын төрийн албан хаагчдын ажлын хариуцлага, бие биедээ тавих зарчимч, ажил хэрэгч санаачлага, ажлын цаг ашиглалт сул байгаа нь төрийн албан хаагчдын ёс зүй, багаар ажиллах чадвар, харьцаа хандлага хангалтгүй байгааг харуулж байна.
4. Байгууллагуудад томилогдсон дотоод хяналтын ажилтан болон баг нь дотоод хяналтын чиг үүргээ сайн ойлгоогүй, хийсэн хяналт нь шаардлагын хэмжээнд хүрэхгүй байгаагаас дотоод хяналт үр нөлөөгүй байна.
5. ЗДТГ, ИТХ-ийн төсвийг үндэслэлгүй тодотгож, хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бусаар зарцуулж, Төсвийн тухай хуулийн холбогдох заалтууд болон УИХ, ЗГ-аас гаргасан төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх арга хэмжээг баримтлан ажиллаагүй, төсвийн үйл ажиллагаанд төрийн сангийн зүгээс тавих хяналт хангалтгүй байна.
6. Сумын ИТХ нь Төсвийн тухай хуулийн 34.2 дах заалтыг үндэслэн төсөвт тодотгол хийгээгүй, орон нутгийн давсан орлого, дансны үлдэгдлийг дараа оны төсвийн эх үүсвэр болгон үр ашигтай байдлаар батлаагүй, сумын ОНХС-ийн хөрөнгөөр

хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг хууль, журам, зааврын дагуу батлаагүй, ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлээгүй байна.

7. Аудитаар өгсөн актыг барагдуулаагүй, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүйгээс өмнө нь гарч байсан зөрчлүүд давтагдсан байна.

ЗӨВЛӨМЖ

Аймгийн Засаг дарга Л.Ганболд-д:

1. Цэцэрлэг сумын төрийн байгууллагуудын үйл ажиллагаа явуулах албан контор, байшин барилгыг бариулах ажлыг төлөвлөж, шийдвэрлэх арга замыг судлах

Сумын ИТХ-ын дарга Дашдаваа-д:

1. Төсвийн тухай хуулийн 34.2 дах заалтыг үндэслэн төсөвт тодотгол хийж, орон нутгийн давсан орлого, дансны үлдэгдлийг дараа оны төсвийн эх үүсвэр болгон баталж байх.
2. Сумын ОНХС-ийн үйл ажиллагаанд тавих хяналтыг үр дүнтэй хийж хэвших

Засаг дарга Цогт-д:

1. Сумын хөгжлийн бодлогын баримт бичгийг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн дагуу боловсруулж, бодитой үнэлэх
2. Орон нутгийн төсвийг үр ашигтай байдлаар төлөвлөж, давсан орлого, дансны үлдэгдлийг дараа оны төсвийн эх үүсвэр болгож байх
3. Аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж ажиллах
4. Багийн Засаг дарга, төсвийн шууд захирагч нартай үр дүнгийн гэрээ байгуулж, үр дүнг бодитой үнэлэх
5. Орон нутгийн орлогыг нэмэгдүүлэх нөөц боломжийг судалж, татвар, төлбөр, хураамжийг бодит байдалд үндэслэн төлөвлөх
6. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төслийг боловсруулах” журмын холбогдох заалтуудыг хэрэгжүүлэн ажиллах
7. Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ыг бүрэн хэрэгжүүлж ажиллах, төслийн сонгон шалгаруулалтыг хийхдээ төсөл бүрийг бүрэн судалж, эргэн төлөгдөх боломжтой, зориулалтын дагуу үйл ажиллагаа явуулах төсөлд зээл олгож, зээлдэгчийн үйл ажиллагаа, эргэн төлөлтөд эхнээс нь хяналт тавин ажиллах
8. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйл, Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан “Журам”-ыг баримтлан ажиллах
9. Цэцэрлэг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн мэдээллийг Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалтын дагуу shilendans.gov.mn цахим хуудсанд хугацаанд нь байршуулж ажиллах

Санхүүгийн албаны дарга Ч.Энхтуяа-д:

1. Сумын санхүүгийн үйл ажиллагаанд төрийн сангийн хяналтыг сайжруулах, санхүүгийн албанаас нягтлан бодогчдыг удирдлага арга зүйгээр хангаж ажиллах

Төсвийн шууд захирагч, нягтлан бодогч нарт:

1. Байгууллагын хэтийн болон тухайн жилийн төлөвлөгөөг Цэцэрлэг сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон Засаг даргын бүрэн эрхийн

хугацаанд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөртэй уялдуулан боловсруулан батлуулж, мөрдөж ажиллах.

2. Төсвийн хөрөнгийг Төсвийн тухай хуулийн холбогдох заалт болон УИХ, ЗГ-аас гаргасан төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх арга хэмжээг мөрдөн ажиллах
3. ЗДТГазар, ИТХурал, Эрүүл мэндийн төв, Могойн эрүүл мэндийн төв, Могойн хүүхдийн цэцэрлэгийн удирдлагуудад шилэн дансны хуулийн 4.1, 6.1 дэх заалтуудыг ханган ажиллах
4. Төрийн албан хаагчдын ёс зүй, багаар ажиллах чадвар, харьцаа хандлагыг сайжруулан ажиллах
5. Дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх
6. Өмнөх хяналт шалгалт болон аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллах

Жич: Аудитын хугацаанд байгууллага бүрт тусгайлан дүгнэлт, зөвлөмж хүргүүлэн ажилласан бөгөөд энэ нь тайлангийн нэг хэсэг болно.

Зөрчлийн жагсаалт

№	Аудитаар илэрсэн		Өгсөн албан шаардлага		Тавьсан акт		Зөвлөмж	
	Зөрчлийн утга	Зөрчлийн дүн /сая төг/	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	ЗДТГ-ын албан контор, Соёлын төвийн барилга, сургуулийн 2 хичээлийн байрыг ашиглах боломжгүй тул аймгийн МХГ-ын улсын байцаагчийн дүгнэлт гарсан ч өдий хүртэл үйл ажиллагаа явуулж байна.						1	
2	Могойн хүүхдийн цэцэрлэг байргүй, одоогийн байдлаар 2 гэрт үйл ажиллагаа явуулж байна.							
3	Сумыг хөгжүүлэх бодлогын баримт бичиг боловсруулахдаа Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дахь заалтын дагуу боловсруулаагүй, зорилго, зорилтын хүрэх түвшин, хугацаа, санхүүгийн эх үүсвэр тодорхойгүй байна.						1	
4	Аймгийн Засаг даргын зүгээс тус сумын Засаг даргын үр дүнгийн гэрээний биелэлтийг 60,8% буюу гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн гэж үзсэн байна.						1	
5	Төсвийн шууд захирагч нарын үр дүнгийн гэрээг үнэлэхдээ Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Менежерийн үйл ажиллагааны үр дүн, мэргэжлийн түвшинг үнэлж дүгнэх журам”-ын дагуу бодитой үнэлээгүй						1	
6	ЗДТГ, ИТХ-ын байгууллагууд нь 2017 онд батлагдсан урсгал төсвийг нэр төрөл тус бүр дээр нь тодотгож, төсвийг хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулах боломжийг бий болгосон байна.	94,1					1	94,1
7	Ойн нөөц ашигласаны төлбөр 12,7 сая төгрөгөөр, бууны татвар 0,9 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.	13,6					1	13,6
8	УИХ-ын 67 дугаар тогтоолын дагуу төрийн албан хаагчдад олгох нэг удаагийн тэтгэмж урамшуулал олгохдоо ЗГХЭГ-ын 2017 оны 52 дугаар хуралдааны тэмдэглэлд заасныг зөрчин олгосон байна	0,729			1	0,729		
9	ЗДТГ-ын спорт заалыг иргэн Л.Пүрэвжаргалтай хийсэн гэрээний төлбөрийг дутуу төвлөрүүлсэн байна.	0,326			1	0,326		

“Цэцэрлэг сумын төрийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүн байдал” гүйцэтгэлийн аудитын тайлан

10	Сумын ЗДТГ нь 2017 онд 3751,6 мянган төгрөгийг хоолны зардалд зарцуулж, үр ашиггүй зардал гаргасан	3,7					1	3,7
11	Сумын ЗДТГ нь тээвэр шатахууны зардалд 2017 онд нийт 22980,0 сая төгрөг зарцуулснаас 15358,1 мянган төгрөгийн шатахууны зардлын тооцоо бодоогүй, томилолтын зардлыг тээвэр шатахууны зардлаар хааж төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.	15,4					1	15,4
12	ЗДТГ нь 12755,0 мянган төгрөгөөр урсгал засвар хийсэн нь УИХ-ын 2016 оны 47 дугаар тогтоолын в-ийн 4 /эмнэлэг, цэцэрлэг, сургуульд зайлшгүй урсгал засвар хийхээс бусад тохиолдолд төсвийн байгууллагын албан контор, ажлын байранд урсгал засвар хийхгүй байх/ гэснийг зөрчсөн байна.	12,7					1	12,7
13	ЗДТГ-ын албан хэрэгцээнд 2016 оны давсан орлогоос 29000,0 мянган төгрөгөөр автомашин худалдан авсан нь УИХ-ын 2016 оны 47 дугаар тогтоолын в-ийн 6 /төсвийн хөрөнгөөр автомашин худалдан авахгүй байх/ гэснийг зөрчсөн байна.	29,0					1	29,0
14	УИХ-ын 2016 оны 47 дугаар тогтоолын в-ийн 5 /төсвийн хөрөнгөөр шууд болон шууд бус хэлбэрээр шинэ жил, баяр ёслолын аливаа арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх/ гэснийг зөрчин шийдвэрийг гаргаж баяр ёслол уралдаан тэмцээнд, хөрөнгө зарцуулахаар төлөвлөсөн байна.	6,9					1	6,9
15	Сумын санхүүгийн үйл ажиллагаанд төрийн сангийн зүгээс тавих хяналт хангалтгүй, санхүүгийн албанаас нягтлан бодогчдыг удирдлага арга зүйгээр хангаж ажиллахгүй байна						1	
16	ЗДТГ-т 4,0 сая төгрөгийн грааш хуурамч бичиг баримтаар орлогод авсан.	4,0	1	4,0				
17	Сумын ИТХ-ын даргын 2017,12,21-ны 10 тоот захирамжаар өөртөө / Ч.Дашдаваа/-д 180,0 мянган төгрөгийн урамшуулал олгосон.	0,18			1	0,18		
18	Ерөнхий боловсролын сургуулийн захиралд 277,4 мянган төгрөгийн, Могойн сургуулийн цэцэрлэгийн цогцолборын захиралд 203,7 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгохдоо тушаал шийдвэргүйгээр олгосон байна.	0,481			1	0,481		
19	ЭМНДГ-ын хяналтын байцаагчийн тавьсан 441,0 мянган төгрөгийн төлбөрийн акт тавигдсаныг сумын ИТХ-ын төсвөөс шилжүүлсэн.	0,441			1	0,441		
20	Цэцэрлэг сумын Эрүүл мэндийн төв нь 2017 онд тендерээс авах ёстой эмийн худалдан авалтыг бүрэн хийгээгүй байна.	5,2					1	5,2
21	Сумын ЭМТөв 2017 онд 2372 л буюу 3795,2 мянган төгрөгийн шатахууныг анхан шатны баримтгүйгээр зарцуулсан, батлагдсан төсвийг 1223,4 мянган төгрөгөөр хэтрүүлсэн, 2018 онд эхний 5 сарын байдлаар 4489,9 мянган төгрөгийн шатахуунийг анхан шатны баримтгүй зарцуулсан зөрчил илэрч байна.	5,7	1	5,7				
22	ЭМТөвийн даргад 2017 оны 3 сард 131,1 мянган төгрөг, 12 дугаар сард 81,9 мянган төгрөг нийт 212,9 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгохдоо тушаал шийдвэргүйгээр олгосон байна.	212,9			1	212,9		
23	ЭМТөв нь хоолны зардлыг 1334,5 мянган төгрөгөөр хэмнэж эмийн зардалд зарцуулсан байна. Өвчтөнд эмчилгээний хоол өгдөггүй тул аудит хийж байх хугацаанд тооцож олгохоор шийдвэрлэв.	1,3					1	1,3
24	Хүүхдийн хоолны зардлаас хүүхдүүдэд Эх үрсийн баяр болон шинэ жилээр бэлэг өгч нэг хүүхдийн хоолны зардлыг 1761,3 мянган төгрөгөөр зарцуулсан байна.	1,8					1	1,8

“Цэцэрлэг сумын төрийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүн байдал” гүйцэтгэлийн аудитын тайлан


25	Могойн Хүн эмнэлгийн эрхлэгчид 2017 оны 3 сард 81,0 мянган төгрөг, 11 дүгээр сард 292,5 мянган төгрөг нийт 372,5 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгоходоо тушаал шийдвэргүйгээр олгосон байна.	0,39			1	0,39		
26	Эрүүл мэндийн төв нь 641,0 мянган төгрөгийн томилолтын зардал, 1557,2 мянган төгрөг урсгал засварын зардал, Хүүхдийн цэцэрлэгт 739,8 мянган төгрөгийн томилолтын зардалд тус тус анхан шатны баримтыг дутуу бүрдүүлсэн байна.	2,9					1	2,9
27	ОНХС-ийн хөрөнгөөр 2017 онд санхүүжигдэх төсөл арга хэмжээний санал асуулгыг хуулийн хугацаанд явуулсан гэх ямар ч нотлох баримт байхгүй байна.	17,1					1	17,1
28	ОНХС-ийн хөрөнгөөр 2018 онд санхүүжигдэх төсөл арга хэмжээний санал асуулгыг хуулийн хугацаанд явуулсан гэх ямар ч нотлох баримт байхгүй байна.	202,9					1	202,9
29	Нийтийн үйлчилгээний граш барих ажлыг гэрээний хугацаанд хийж гүйцэтгээгүй байхад “Жарантайн намаг” ХХК-д 2017.12.24-нд 4000,0 мянган төгрөгийг шилжүүлсэн ба анхан шатны баримт материалыг хуурамчаар хийж гүйцэтгэн баталгаажуулсан байна.	4,0			1	4,0		
30	Гудамж талбай камержуулах ажлын гэрээг 8000,0 мянган Жигүүр Фүүд ХХК-тай гэрээ хийсэн, гүйцэтгэгчээс гэрээнд заасан дүнгээр нэхэмжлэл ирүүлсээр байтал 8060,4 мянган төгрөг шилжүүлж 60,4 мянган төгрөгийг илүү олгосон байна.	0,06			1	0,06		
31	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн ерөнхий боловсролын сургуулийн 320 хүүхдийн хичээлийн байрны зураг төсвийн үнэд 2013 онд 17900,0 мянган төгрөг, 2015 онд 6900,0 мянган төгрөг, 2017 онд 1654,4 мянган төгрөг нийт 35800,0 мянган төгрөгийг ТЭТҮ ХХК-д шилжүүлсэн ба зураг төсвийг орлогод аваагүй, тус мөнгийг авлагаар бүтгээгүй байна.	25,8	1	25,8				
32	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Журам”-ын холбогдох заалтуудыг бүрэн хэрэгжүүлээгүй, худалдан авах ажиллагааны баримт материалыг архивын нэгж болгож үдэж цэгцлээгүй байна.		1					
33	Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр олгосон зээлээс 6.1 сая төгрөгийн хүүгийн орлого олох боломжийг алдсан байна.	6,1					1	6,1
34	2017 онд олгосон 14.5 сая төгрөгийн зээл авсан 2 зээлдэгч төслийн дагуу үйл ажиллагаагаа явуулаагүй байна	14,5					1	14,5
35	Өмнөх хяналт шалгалтаар өгөгдсөн акт, албан шаардлага зөвлөмжийн биелэлт хангалтгүй байна							
36	Нийт дүн	469,63	7	52,6	9	6,93	17	410,1

Холбогдох байгууллагын санал:


Ирүүлсэн санал

Хариу





1. Санал хүлээн авах боломжгүй байна.
2. Санал хүлээн авах боломжгүй байна.
3. Тайлангийн дүн, дүгнэлттэй санал нэг байна гэж үзлээ.



4. Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан журмын 12.2.5 дах заалт нь ЗДТГ-ын үйл ажиллагаа байгаа болно. Иймд санал хүлээн авах боломжгүй байна.
5. Бусад акт албан шаардлагыг хүлээн авсан байна гэж үзлээ.

хариу албан ёсоор өнөөдрийг хүртэл Цэцэрлэг сумын ЗДТГ-т албан ёсоор ирээгүй бөгөөд албан ёсоор хүлээн зөвшөөрч гарын үсэг зурж, баталгаажуулж хүлээж аваагүй тул акт гэж хүлээн зөвшөөрөхгүй байна. Учир нь барагдуулж биелүүлэх хугацааны хувьд хяналт шалгалт хийсэн хугацаанаас хойш 3 хоногийн дотор барагдуулах гэх мэт боломжгүй зүйлүүд нэлээд байсан.

ЗДТГ-ЫН ДАРГА



Н. ПҮРЭВСҮРЭН

Сумын Засаг дарга, ИТХ-ын дарга болон бусад төрийн байгууллагуудын удирдлагуудаас гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд санал ирүүлээгүй тул санал нэгтэй байна гэж ойлгосон болно.



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ

2018 оны 06 сарын 29 өдөр

Дугаар А/32

Мөрөн сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/125 дугаар тушаал, 2017 оны А/188 дугаар тушаалын тавдугаар хавсралтын 2.4 дэх заалт, 2016 оны А/92 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын журам”-ын 12.40 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу “Цэцэрлэг сумын төрийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.

2. Аудитаар өгсөн акт, албан шаардлагыг хавсралтаар баталгаажуулсугай.

3. Аудитын тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймгийн Засаг дарга, Цэцэрлэг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга болон бусад төсвийн байгууллагын удирдлагуудад тус тус хүргүүлсүгэй.

4. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж үр дүнг 2018 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор багтаан Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга (Ч.Дашдаваа), Засаг дарга (Д.Цогт), Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Пүрэвсүрэн), Ерөнхий боловсролын сургуулийн захирал (Х.Төрмөнх), Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч (Г.Даваажав), Соёлын төсвийн эрхлэгч (Ж.Азжаргал), Эрүүл мэндийн төвийн дарга (Б.Баатар), Могойн Эрүүл мэндийн төвийн дарга (Э.Нямдаваа), Могойн хүүхдийн цэцэрлэг, бага сургуулийн захирал (Б.Эрдэнэчимэг) нарт зөвлөсүгэй.

5. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер (Г.Эрдэнэчимэг), ахлах аудитор (Б.Тэгшдэлгэр) нарт даалгасугай.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



О.ГАНБОЛД

2018.06.29

1551132

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга бөгөөд тэргүүлэх аудиторын 2018 оны
06 дугаар сарын 29-ний өдрийн
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

“ЦЭЦЭРЛЭГ СУМЫН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН-Д ХИЙСЭН
ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТААР ТОГТООСОН АКТ, АЛБАН ШААРДЛАГЫН ЖАГСГАЛТ

№	Төлбөр хариуцагч байгууллага	Дугаар		Тогтоосон ажилтан	Төлбөр, зөрчлийн товч утга	Актын төлбөрийн дүн /мян.төг/	Албан шаардлагын төлбөрийн дүн /мян.төг/
		Төлбөрийн акт	Албан шаардлага				
1	Сумын ЗДТГ		ХӨА-2018/04/Г А-02/30	Ахлах аудитор Б.Тэгшдэлгэр	ЗДТГ-т биетээр оршин байхгүй 4000000 төгрөгийн нийтийн грашийг нягтлан бодох бүртгэлд бүртгэсэн. Ерөнхий боловсролын сургуулийн 320 хүүхдийн хичээлийн байрны зураг төсвийн 25789100 төгрөгийг нягтлан бодох бүртгэлд авлагаар бүртгээгүй байна.		29789.1
2	Сумын Эрүүл мэндийн төв		ХӨА-2018/04/Г А-01/29	Аудитор Л.Магсаржалам	Тээвэр шатахууны зардлыг анхан шатны баримтгүй, аривлан хэмнэлтгүй зарцуулсан.		5713.3
3	Сумын ИТХ	ХӨА-2018/04/ГА-09/14		Ахлах аудитор Б.Тэгшдэлгэр	Сумын ИТХ-ын даргын 2017.12.21-ны 10 тоот захиралжаар Ч.Дашдаваад 180000 төгрөгийн урамшуулал олгосон байна. ЭМНДГ-ын хяналтын байцаагчийн тавьсан 441000 төгрөгийн төлбөрийн актыг сумын ИТХ-ын төсвөөс шилжүүлсэн байна.	621.0	
4	Сумын ЗДТГ	ХӨА-2018/04/ГА-08/13		Ахлах аудитор Б.Тэгшдэлгэр	“Жигүүр Фүүд” ХХК-д 60400 төгрөгийг илүү олгосон байна.	60.4	

5	Сумын *ЗДТГ	ХӨА- 2018/04/ГА- 05/10		Ахлах аудитор Б.Тэгшдэлгэр	Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх нийтийн үйлчилгээний гравш барих ажлыг гэрээний хугацаанд хийж гүйцэтгээгүй ажилд хуурамч баримт бичгээр 4000,0 мянган төгрөг олгосон байна.	4,000.0	
6	Сумын ЗДТГ	ХӨА- 2018/04/ГА- 07/12		Ахлах аудитор Б.Тэгшдэлгэр	УИХ-ын 2017 оны 67 дугаар тогтоолыг зөрчин нэр бүхий 3 хүнд 729000 төгрөгийг олгосон байна.	729.0	
7	Сумын ЗДТГ	ХӨА- 2018/04/ГА- 06/11		Ахлах аудитор Б.Тэгшдэлгэр	ЗДТГ-ын спорт заалыг иргэн Л.Пүрэвжаргал түрээсийн төлбөр 326000 төгрөгийг төлөөгүй байна.	326.0	
8	Сумын Ерөнхий боловсрол ын сургууль	ХӨА- 2018/04/ГА- 04/09		Аудитор С.Гансүх	Ерөнхий боловсролын сургуулийн захиралд 2017 оны 10-р сарын цалинд АЗД-ын захирамж үндэслэлгүй урамшуулал олгосон.	220.2	
9	Могойн бага сургууль	ХӨА- 2018/04/ГА- 03/08		Аудитор С.Гансүх	Могойн бага сургуулийн захиралд АЗД-ийн захирамжийг үндэслэлгүй урамшуулал олгосон байна.	183.5	
10	Сумын Эрүүл мэндийн төв	ХӨА- 2018/04/ГА- 02/07		Аудитор Л.Магсаржала м	Сумын ЭМТ-ийн даргад тушаал шийдвэргүйгээр урамшуулал олгосон.	212.9	
11	Могойн Эрүүл мэндийн төв	ХӨА- 2018/04/ГА- 01/06		Аудитор Л.Магсаржала м	ЭМТ-ийн даргад тушаал шийдвэргүйгээр урамшуулал олгосон.	389.9	
Нийт						6742.9	35502.4

* 00000